



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 05

Чингис хот

Салбар комисс байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.2.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.3, 2019 оны 15 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын 3.1, 3.3, 3.4, 6.1, 11.1-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны ерөнхий шалгалтыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах, шалгалттай холбоотой иргэдээс гарсан санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх салбар комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, танхимын багтаамж, тоног төхөөрөмжийн хүрэлцээ зэргээс шалтгаалан шалгалтыг хэсэгчлэн зохион байгуулах тул дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулахад дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг арга зүйгээр хангаж, холбогдох хууль, журмын хүрээнд шударга, ил тод, иргэдийг адил тэгш боломжоор хангах зарчмыг баримталж, алдаа, маргаангүй зохион байгуулахад анхаарч ажиллахыг дэд ажлын хэсгийн ахлагч нарт даалгасугай.

3. Төрийн албаны ерөнхий шалгалтын тайлан, холбогдох материалыг хугацаанд нь Төв комисст хүргүүлэхийг нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 05 дугаартай тогтоолын нэгдүгээр хавсралт



ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар комиссын дарга:	Ж.Ганбаатар	-Салбар зөвлөлийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Ж.Саруултөгс	-Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Гантулга	-Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Л.Бат-Октябрь	-Салбар зөвлөлийн гишүүн, Хууль эрх зүйн хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан	-Салбар зөвлөлийн гишүүн, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Б.Сүнгээ	-Салбар зөвлөлийн гишүүн, Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Г.Болд	-Салбар зөвлөлийн гишүүн, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 05 дугаартай тогтоолын хоёрдугаар хавсралт



ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1 дүгээр ажлын хэсгийн ахлагч:

	Ж.Гантулга	-Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Саруултөгс	-Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн
	С.Оюун-Эрдэнэ	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал, байууллагын өргөдөл, гомдол, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
	Л.Наранбат	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Дотоод, гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Батбаяр	-Хэрлэн лаборатори 1 дүгээр сургуулийн Мэдээлэл зүйн багш

2 дугаар ажлын хэсгийн ахлагч:

	Г.Лхагвахатан	-Салбар зөвлөлийн гишүүн, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:	С.Бат-Эрдэнэ	-Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
	Д.Өнөрцэцэг	-Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого хариуцсан мэргэжилтэн
	Л.Мөнхбаатар	-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Нийгмийн бодлого хариуцсан ажилтан
	Ц.Мандахбаяр	-Хан Хэнтий цогцолбор сургуулийн Мэдээлэл зүйн багш

3 дугаар ажлын хэсгийн ахлагч:

	Г.Болд	-Салбар зөвлөлийн гишүүн, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Ч.Эрдэнэбаатар	-Салбар зөвлөлийн гишүүн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
	Т.Алтаншагай	- Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын Дотоод ажил, мэдээлэл технологийн мэргэжилтэн

	Д.Тогоонпүрэв	- Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Л.Бямбадорж	-Тэмүүжин цогцолбор сургуулийн Мэдээлэл зүйн багш
4 дүгээр ажлын хэсгийн ахлагч:		
	Б.Сүнгээ	-Салбар зөвлөлийн гишүүн, Мэргэжлийн хяналтын газрын дарга
Гишүүд:	Б.Баярсайхан	-Салбар зөвлөлийн гишүүн, Шүүхийн тамгын газрын дарга
	Ц.Туяасайхан	-Мэргэжлийн хяналтын гарын Хүний нөөц, эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Д.Оюун-Эрдэнэ	-Шүүхийн тамгын газрын Мэдээлэл, лавлагааны мэргэжилтэн
	Г.Батцэнгэл	-Хэрлэн 4 дүгээр сургуулийн Мэдээлэл зүйн багш
5 дугаар ажлын хэсгийн ахлагч:		
	Л.Бат-Октябрь	-Салбар зөвлөлийн гишүүн, Хууль эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүд:	Ч.Баярцолмон	- Салбар зөвлөлийн гишүүн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
	Ц.Ганчимэг	- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Агентлаг, нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Н.Нарантуяа	- Хууль эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомжийн мэдээлэл, системчлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
	Б.Сувд-Эрдэнэ	-Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн Мэдээлэл зүйн багш